



PRESS RELEASE

MONGOLIA: TIME TO MOVE FROM PROMISES TO ACTIONS

NOVEMBER 14, 2018
ULAANBAATAR, MONGOLIA

Over the last two days, 12-13 November 2018, the Asian Forum for Human Rights and Development (FORUM-ASIA) and its members from Mongolia, the Centre for Human Rights and Development (CHRD) and Globe International (GI), organised a joint consultation on National Human Rights Defenders “Advancing Human Rights and Development” in the country. The consultation brought together various stakeholders in addressing human rights issues, including human rights organisations, human rights defenders from both Ulaanbaatar and rural areas, as well as representative from the Ministry of Foreign Affairs and the National Human Rights Commission. A Malaysian lawyer and freedom of expression expert also joined to share his experience and insights.

During the two-day discussion, participants concluded that human rights defenders in Mongolia are still vulnerable to threats, intimidation, and harassment from both state and non-state actor particularly foreign and domestic companies operating in rural areas. Human rights defenders are an integral part of a democracy in any country and have important role to ensuring that development is sustainable, inclusive and non-discriminatory in Mongolia. Whether they are environmental activists, journalists, herders, students, trade unionists or of any other profession, they should be able to express themselves freely and carry out their peaceful work without fear of reprisal. In this regard, the state plays a crucial role to create an enabling environment by; repealing repressive laws and provisions; enacting pro-human rights laws and policies in line with international human rights standards; and ensuring that such laws and policies are effectively implemented equally without any discrimination.

There are three main areas of concern, which came up during this year’s consultation¹, being: (i) curtailing of freedom of expression, in particular through the proposed amendment on the defamation

¹ FORUM-ASIA together with its members and partners have been organizing an annual national consultation on HRDs since 2015, and this is the 4th consultation. The past three consultations have resulted in concrete steps and recommendation on human rights issues particularly how to develop a strong network of human rights defenders and how to create enabling environment for the work of defenders in Mongolia.

clause in the Criminal Code and Libel clause of the Law on Administrative offence²; (ii) developing effective law on protection of human rights defenders and how to enact the law and (iii) disruptive business activities, in particular mining and large development project, and their adverse human rights impact. While some progress has been made over the past year when it comes to these areas of concern, in other instances there has been actually been regress. While there is a positive progress on drafting the law on human rights defenders protection under the leadership of the Mongolian National Human Rights Commission (MNHRC) in consultation with CSOs, negative impacts of mining and agriculture companies' operation have been intensified especially for local communities and herders.

Human rights defenders including journalists strongly oppose the inclusion of defamation as a criminal offence and the Libel clause under the Law on Administrative Offences. Such a provision will have a chilling effect on society and will stifle freedom of expression. If the proposed amendment is enforced, this would be a step backward by the Government. The right to freedom of expression is guaranteed for everyone under the Constitution of Mongolia and international human rights standards. Human rights defenders, including journalists, have an important role in holding the Government accountable, and the State must ensure they are able to do so. Participants of the consultation also encourage the Government to review all legislation that can be used to stifle freedom of expression, in particular the proposed amendment on defamation to the Criminal Code, and to ensure the active participation of all stakeholders in the amendment process.

During the discussion on the draft human rights defenders protection law, the network of human rights defenders in Mongolia welcomed efforts made by key human rights actors in the country, such as the Mongolia National Human Rights Commission (MNHRC) and the human rights sub-committee of Parliament. However, participants to the consultation believe that some provisions in the latest draft law can still be strengthened to ensure substantive and holistic protection of human rights defenders in Mongolia, including the clearer definition of human rights defenders, the role they have in the protection committee as well as an inclusion of local authorities' protection obligation. Such a review is important to ensure the inclusivity of the law, and effective implementation.

Participants also pointed out that business operations, such as mining, take place without effective control mechanisms, while environmental defenders and herders continue to be affected by business operation. In this context, participants noted that since the United Nations Working Group on Business and Human Rights visit in 2012, there has been no meaningful progress from the Government to develop a National Action Plan (NAP) on Business and Human Rights. The NAP should articulate the State's priorities and actions to protect against the adverse impact of business operations, as well as clarify how businesses should discharge their responsibilities to respect human rights. The Government should ensure that the NAP is based on international human rights standards, in conformity with the United Nations Guiding Principles on Business and Human Rights as well as covering key issues such as mining companies'

² The Law on Administrative Offences was enforced since July in 2017. Since then over 230 journalists, media staffs and social media users have been charged under article 6.21 of the Law.

practices, land distribution and labor rights. It should take into account the inputs from civil society organisations and affected communities through a genuine open and consultative process.

Some progress on human rights has been made over the past year in Mongolia. However, human rights defenders are still subject to intimidation and harassment. As a champion of democracy in East Asia, the Government of Mongolia needs to play a proactive role in the protection of human rights defenders, by creating an enabling legal environment and ensuring the effective implementation of laws and policies. By doing so, the protection and fulfilment of human rights may fully be achieved in the country.

FORUM-ASIA
Center for Human Rights and Development
Globe International
National Human Rights Defenders Network



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

МОНГОЛ УЛС: АМЛАЛТААС ҮЙЛ АЖИЛЛАГАА РҮҮ ШИЛЖИХ ЦАГ БОЛЛОО

2018 ОНЫ 11-Р САРЫН 18 ӨДӨР
УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

Олон улсын Хүний Эрх, Хөгжлийн Азийн Форум (FORUM-ASIA), Монгол дахь гишүүн байгууллага Хүний Эрх Хөгжил Төв, Глоб Интернэшнл Төвтэй хамтран 2018 оны 11-р сарын 12-13-ны өдөр “Хүний эрх болон хөгжлийг хөхиүлэн дэмжих нь” Үндэсний хүний эрхийг Хамгаалагчдын хамтарсан зөвлөгөөн Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгууллаа. Улаанбаатар хот болон орон нутгийн хүний эрхийн байгууллага, хүний эрхийг хамгаалагчид, Монгол улсын ГХЯ, ХЭҮК-ын төлөөлөл зэрэг олон оролцогч цугларан хүний эрхийн тулгамдсан асуудлуудыг ярилцан хэлэлцлээ. Малайз улсын хуульч-өмгөөлөгч, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чиглэлээр мэргэшсэн шинжээчид зөвлөгөөнд оролцож туршлагаа хуваалцав.

Хоёр өдөр үргэлжилсэн хэлэлцүүлгийн явцад Оролцогчид, хүний эрхийг хамгаалагчид ялангуяа хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон дотоодын компаниудын заналхийлэл, доромжлол, сүрдүүлэгт өртөх магадлалтай хэвээр байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Хүний эрхийг хамгаалагчид аливаа улс орны ардчиллын салшгүй нэг хэсэг мөн бөгөөд Монгол улсын тогтвортой, оролцоот, ялгаварлан гадуурхалтаас ангид хөгжлийг хангахад онцгой үүрэг гүйцэтгэдэг. Байгаль орчны идэвхтэн, сэтгүүлч, оюутан, үйлдвэрчний эвлэлийн ажилтан, мөн бусад мэргэжлийн ажилтнууд өөрсдийгөө чөлөөтэй илэрхийлж, шийтгэлээс айлгүйгээр ажлаа тайван амгалан хийх боломжтой байх ёстой. Дарангүй хууль, заалтуудыг хүчингүй болгох, хүний эрхийн олон улсын стандартад нийцсэн хүний эрхийг дээдэлсэн, хамгаалсан хууль, журмыг батлах, баталсан хууль, журмууд нь хэн нэгнийг ялгаварлан гадуурхалгүйгээр хүн бүрт тэгш үйлчилдэг байх орчныг Төр бүрдүүлэх үүрэгтэй.

Энэ удаагийн зөвлөгөөнөөр³ санаа түгшээж буй гурван гол зүйлд анхаарал хандууллаа. Үүнд: нэгдүгээрт, Эрүүгийн хуулинд гүтгэлгийн тухай зүйл заалтыг оруулах санал, Зөрчлийн тухайн хуульд

³ Форум-Ази өөрийн гишүүд, түншүүдтэй хамтран 2015 оноос хойш Хүний Эрхийг Хамгаалагчдын Үндэсний зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж ирсэн бөгөөд энэ жил 4 дэх удаагийн зөвлөгөөнийг явуулж байна. Өмнөх гурван зөвлөгөөнөөс Монгол улсад хүний эрхийг хамгаалагчдын хүчирхэг сүлжээг хэрхэн бий болгох, хамгаалагчдад ажил хийх орчныг хэрхэн бүрдүүлж өгөх зэрэг хүний эрхийн талаар тодорхой алхмууд хийж зөвлөмж гаргасан.

буй гүтгэлгийн тухай зүйл заалт⁴, хоёрдугаарт, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах үр нөлөө бүхий хуулийн төсөл, хууль батлах үйл явц, гуравдугаарт, уул уурхай, хөгжлийн томоохон төслүүдийн хортой үйл ажиллагаа, хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөө гэсэн үндсэн гурван асуудлыг хөндөж ярилцлаа.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд ахиц дэвшил байсан хэдий ч анхаарал татаж буй эдгээр асуудлын хувьд зарим талаар ухарсан гэж болохоор байна. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс манлайлан иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулсан Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хуулийн төсөл боловсруулсан эерэг ахицын зэрэгцээ уул уурхай, газар тариалангийн компаниудын үйл ажиллагаа, орон нутгийн иргэд, малчдад үзүүлж буй сөрөг нөлөө ихээхэн нэмэгджээ.

Сэтгүүлчдийг хамруулан хүний эрхийг хамгаалагчид нэр хүндэд халдах, ялангуяа гүтгэлгийн тухай зүйл заалтыг эрүүгийн шийтгэл гэж үзэх, Зөрчлийн тухай хуульд буй Гүтгэлэг гэсэн заалт оруулсныг эрс эсэргүүцэж байна. Эдгээр зүйл заалт нь нийгмийг айдаст автуулах сөрөг нөлөөтэй төдийгүй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нүхчин дарж буй хэрэг мөн. Монголын төр Эрүүгийн хуулийн төсөлдөө санал болгож буй энэ нэмэлт өөрчлөлтийг баталбал хойш ухарсан хэрэг болно. Монгол Улс хүн бүрийнхээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн Хуулиараа, мөн олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу баталгаажуулсан. Хүний эрхийг хамгаалагчид, үүний дотор сэтгүүлчид, Засгийн Газрыг иргэдийнхөө өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг ба энэ боломжийг Төр олгох ёстой. Засгийн Газар Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлан боомилоход ашиглагдаж болохуйц бүхий л хууль, тогтоомж, ялангуяа Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлтөөр оруулах гэж буй нэр хүндэд халдах, гүтгэх заалтаа эргэн нягталж, хуулийн төсөл хэлэлцэх үйл явцдаа бүх талын оролцоог хангах ёстой гэж зөвлөгөөнд оролцогчид үзлээ.

Монголын хүний эрхийг хамгаалагчдын сүлжээнийхэн Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн үеэр Хүний Эрхийн Үндэсний Комисс, УИХ-ын Хүний Эрхийн Дэд Хороо зэрэг хүний эрхийн чиглэлийн гол оролцогчдын хүчин чармайлтыг талархан сайшаасан билээ. Үүний зэрэгцээ, Монголын хүний эрхийг хамгаалагчдыг бүрэн бодит хамгаалалтаар хангах зорилготой энэхүү хуулийн төслийн сүүлийн хувилбарын зарим заалт, тодруулбал, хүний эрхийг хамгаалагч гэсэн тодорхойлолтыг ойлгомжтой болгох, Хамгаалалтын Хороонд тэдний гүйцэтгэх үүрэг, хүний эрхийг хамгаалахад орон нутгийн удирдлагад үүрэг хүлээлгэх зэрэг заалтыг илүү тодорхой болгож, чангатгах зэргээр илүү сайжруулах шаардлагатайг Зөвлөгөөнд оролцогчид зөвлөж байна. Ийнхүү эргэж нягтлах нь хуулийн хамрах хүрээ, үр нөлөө бүхий хэрэгжилтийг хангахад нэн чухал юм.

Уул уурхай зэрэг бизнесийн үйл ажиллагаа тодорхой хяналтгүйгээр явагдаж, тэдний үйл ажиллагааны нөлөөлөлд байгаль орчныг хамгаалагчид, малчид өртсөн хэвээр байгааг Оролцогчид хөндөж хэлэлцсэн төдийгүй НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Ажлын хэсэг 2012 онд Монгол Улсад ажлын айлчлал хийснээс хойш Бизнес ба Хүний Эрхийн Үйл ажиллагааны Үндэсний Хөтөлбөр боловсруулах талаар Засгийн Газар онцгой ахиц гаргаагүйг Оролцогчид тэмдэглэв. Үйл ажиллагааны

⁴ Захиргааны Зөрчлийн тухай хууль 2017 оны 7-р сараас мөрдөгдөж эхэлсэнээс хойш 230 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, нийгмийн сүлжээ хэрэглэгч энэ хуулийн 6.21-р зүйлийн дагуу шийтгэгдээд байгаа болно.

үндэсний хөтөлбөрт бизнесийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, бизнесийн байгууллагууд хүний эрхийн чиглэлээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх ёстойг тодотгоход төрийн нэн тэргүүний зорилтууд, үйл ажиллагааг багтаасан байх ёстой. Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр нь олон улсын хүний эрхийн хэмжээнд үндэслэгдсэн, НҮБ-ын Бизнес болон Хүний эрхийн мөрдөх зарчмуудад нийцсэн байхаас гадна уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, газар олголт, хөдөлмөрийн эрх зэрэг үндсэн асуудлыг багтаасан эсэхэд Засгийн Газар хяналт тавих үүрэгтэй төдийгүй зөвлөлдөх үйл явцыг бүрэн нээлттэй эхлүүлж, иргэний нийгмийн байгууллага, нөлөөлөлд өртсөн ард иргэдийн санал бодлыг харгалзан үзэх ёстой.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Монгол улс хүний эрхийн асуудлаар зарим ахиц амжилт гаргасан хэдий ч хүний эрхийг хамгаалагчид доромжлол, дарамттай нүүр тулсаар байна. Зүүн Азийн бүс нутагт ардчиллын анхдагч болсны хувьд Монгол Улсын Засгийн Газар эрхзүйн орчин бий болгох, хууль, бодлогоо үр нөлөөтэй хэрэгжүүлэх замаар хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэх шаардлагтай байна. Ингэснээр улс орондоо хүний эрхийг бүрэн хамгаалж, хангаж чадна.

Олон улсын Форум Ази байгууллага
Хүний Эрх Хөгжил Төв
Глоб Интернэшнл төв
Үндэсний Хүний Эрхийг Хамгаалагчдын Сүлжээ